



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/296

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын Төв дөрвөн замын уулзварын гэрлэн дохионы засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Гантөмөр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Н.Цацралцэцэг – Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний улсын хяналтын байцаагч

Ц.Цогтбаяр – Жаргалант сумын Засаг даргын орлогч

Н.Балжинням – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч

У.Пүрэвдорж – Ховд "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ий Ерөнхий инженер


Л.Дорждэрэм – Жаргалант сумын хот тохижуулах газрын дарга

Нарийн бичгийн

дарга: Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2.Ховд аймгийн Жаргалант сумын Төв дөрвөн замын уулзварын гэрлэн дохионы засварын ажлыг хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /С.Гантөмөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДУГЭРЖАВ

